



МОНГОЛ УЛСЫН
ДАЛАЙН ЗАХИРГААНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Сургалтын хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь хэсэг, Далайн захиргааны дүрмийн 3 дугаар зүйлийн 3.6 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.1.11 дэх заалт, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.2.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Далайн захиргааны ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх 2023 оны сургалтын хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг зохих журмын дагуу санхүүжүүлэхийг Нягтлан бодогч (Б.Нэмжбадгар)-д зөвшөөрсүгэй.

3. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга (Ю.Өлзийжаргал)-д үүрэг болгосугай.


ДАРГА

Д.ОТГОНСҮРЭН



0000000011

Далайн захиргааны даргын 2023 оны
 09 дугаар сарын 16 ны өдрийн
 0/06 дугаар тушаалын хавсралт



ДАЛАЙН ЗАХИРГААНЫ АЖИЛТНУУДЫН МЭРГЭЖИЛ, УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ 2023 ОНЫ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

№	Сургалтын төрөл, чиглэл	Сургалтын зорилго	Зохион байгуулах хугацаа	Сургалтанд хамрагдах ажилтнууд	Санхүүжилт
1	Төрийн болон албаны нууцын тухай хуулийг таниулан сурталчлах сургалт	Байгууллага, хувь хүний нууцлал, хэм хэмжээ, ёс зүйн мэдлэг ур чадвар эзэмшинэ.	Жилдээ	Нийт ажилтнууд	Байгууллагын төсөв
2	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх арга зам	Хуулийн хэрэгжилттэй холбоотой соён гэгээрүүлэх арга хэмжээ авснаар улс төр, нийгэм соёлын ба ажлын байранд жендэрийн эрх тэгш байдлыг хэрхэн хангах талаар арга зүйтэй болно.	Жилдээ	Нийт ажилтнууд	Байгууллагын төсөв
3	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, холбогдох стандарт, дүрэм, журмыг хэрэгжүүлэх сургалт	Далайн захиргааны ХАБЭА-н орон тооны бус Зөвлөлийн 2023 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Жилдээ	Нийт ажилтнууд	ХАБЭА-н төсөв
4	Авлигын эсрэг сургалт	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийн талаарх мэдлэг сайжирна.	Жилдээ	Нийт ажилтнууд	Байгууллагын төсөв эсхүл зохион байгуулагч талын зардлаар
5	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийн сургалт	Гэмт хэрэг үйлдэх нөхцөл бололцоог багасгах, албан хаагчид өөрсдийн бие махбодийг төдийгүй эд хөрөнгийнхөө аюулгүй байдлыг хангах, сонор сэрэмжтэй байх чадвар эзэмшинэ.	Жилдээ	Нийт ажилтнууд	Байгууллагын төсөв эсхүл зохион байгуулагч талын зардлаар

6	Архив, албан хэрэг хөтлөлт	Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан.	1-2-р улиралд /Архивын ерөнхий газрын 2023 оны сургалтын төлөвлөгөөнд заасан хугацаанд/	Холбогдох мэргэжилтэн	Байгууллагын төсөв
7	Байгууллагын сэтгэл зүйн сургалт	Ажлын байрны стрессийг бууруулж, байгууллагын уур амьсгалыг эерэг болгож, ажилтнуудын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх	Жилдээ	Нийт ажилтнууд	ХАБЭА-н төсөв
8	Төрийн худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох сургалт /АЗ сертификаттай/	Далайн захиргааны 2023 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг зохион байгуулах	1-р улиралд	Холбогдох мэргэжилтнүүд	1 хүний 85,000 төгрөг
9	Англи хэлний зохих шатны сургалт	Англи хэлний мэдлэг зохих түвшинд сайжирна.	Жилдээ	Нийт ажилтнууд	Байгууллагын төсөв
10	Монгол бичгийн сургалт	Байгууллагын монгол бичгийн мэдлэг зохих түвшинд сайжирна.	Жилдээ	Нийт ажилтнууд	Байгууллагын төсөв
11	ЗТХЯ болон бусад холбогдох байгууллагуудаас зохион байгуулах мэдээллийн технологийн чиглэлийн сургалт	Мэдээлэл, технологийн чиглэлээр мэргэжлийн ур чадвар сайжирна.	Жилдээ	Мэдээллийн сүлжээ, техник хангамж хариуцсан мэргэжилтэн	Байгууллагын төсөв эсхүл зохион байгуулагч талын зардлаар
12	Дэлхийн далайн их сургууль, Далайн хуулийн институт болон холбогдох далайн салбарын олон улсын их дээд сургуулиудад албан хаагчдыг шаардлагатай мэргэжлээр суралцуулах	Мэргэжлийн ур чадвар дээшилнэ. Байгууллагын үйл ажиллагаа сайжирна.	Жилдээ	Шаардлага хангасан ажилтан	Байгууллагын төсөв эсхүл зохион байгуулагч талын зардлаар
13	Олон улсын далайн байгууллага /ОУДБ/-ын техникийн хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулах сургалт, семинар	Мэргэжлийн ур чадвар дээшилнэ. Техникийн хамтын ажиллагаа өргөжнө.	Жилдээ	Холбогдох ажилтан	Байгууллагын төсөв эсхүл зохион байгуулагч талын зардлаар



14	Далайн захиргааны хамтын ажиллагаа тогтоосон гадаад, дотоодын байгууллагаас зохион байгуулах сургалт, семинар	Мэргэжлийн ур чадвар дээшилнэ. Гадаад хамтын ажиллагаа сайжирна.	Жилдээ	Холбогдох ажилтан	Байгууллагын төсөв эсхүл зохион байгуулагч талын зардлаар
15	ОУДБ болон бусад холбогдох байгууллагаас зохион байгуулах олон улсын гэрээ конвенцын хэрэгжилтийг хангах чиглэлийн сургалт	Олон Улсын гэрээ эрх зүй хариуцсан мэргэжилтний мэргэжлийн ур чадвар сайжирна.	Жилдээ	Холбогдох ажилтан	Байгууллагын төсөв эсхүл зохион байгуулагч талын зардлаар
16	Далайн осол, зөрчилтэй холбоотой олон улсын байгууллагаас зохион байгуулах сургалт	Далбааны эзэн улсын гүйцэтгэл сайжирна.	Жилдээ	Хөлөг онгоцны бүртгэл, хяналтын алба	Байгууллагын төсөв эсхүл зохион байгуулагч талын зардлаар
17	Далбааны эзэн улсын үүргийн хэрэгжилтийг сайжруулах сургалт, семинар	Далбааны эзэн улсын гүйцэтгэл сайжирна.	Жилдээ	Хөлөг онгоцны бүртгэл, хяналтын алба	Байгууллагын төсөв эсхүл зохион байгуулагч талын зардлаар
18	ОУДБ болон бусад холбогдох байгууллагаас зохион байгуулах хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой сургалт	Хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагаа сайжирна.	Жилдээ	Хөлөг онгоцны бүртгэл, хяналтын алба	Байгууллагын төсөв эсхүл зохион байгуулагч талын зардлаар
19	Боомт улсын хяналт шалгалтын талаарх сургалт	Далбааны эзэн улсын гүйцэтгэл сайжирна.	Жилдээ	Хөлөг онгоцны бүртгэл, хяналтын алба, Усан замын тээврийн бүртгэл, хяналтын алба	Байгууллагын төсөв эсхүл зохион байгуулагч талын зардлаар
20	Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын олон улсын судалгааны төвөөс зохион байгуулах лекц, семинар	Далайд гарцгүй бусад хөгжиж буй орнууд болон хөгжингүй орнуудын туршлагаас судлах, энэхүү НҮБ-ын судалгааны төвийн санхүүжилтээр Монгол Улсад уригдан ирж буй салбарын эрдэмтэн судлаач,	Жилдээ	Далайн тээвэр, боомт ашиглалт хариуцсан алба	Тухайн байгууллагын төсөв

		мэргэжилтнүүдээс суралцан бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, удирдлагыг мэдээллээр хангах			
21	Далайн тээвэр, боомт ашиглалтын талаарх сургалт	Хуурай боомтын төлөвлөлт, удирдлагатай холбоотой мэргэжлийн ур чадвар нэмэгдэнэ.	3 сар	Далайн тээвэр, боомт ашиглалт хариуцсан алба	Сургалтын зардал (2770 ам.доллар-9,500.000 төгрөг)
22	Тээвэр логистикийн удирдлагын талаарх сургалт	Тээвэр логистикийн мэргэжлийн баримжаа, ур чадвар нэмэгдэнэ.	3 сар	Далайн тээвэр, боомт ашиглалт хариуцсан алба	Сургалтын зардал (2837 ам.доллар 9,800.000 төгрөг)
23	Тээвэр логистикийн талаарх цахим сургалтууд	Мэргэжлийн ур чадварыг дээшлүүлнэ.	7 хоног	Далайн тээвэр, боомт ашиглалт хариуцсан алба	500 ам.доллар (1,700.000 төгрөг)
24	Байгууллагын нийтлэг соёл болон хувь хүний хөгжилд чиглэгдсэн сургалтууд	Байгууллагын хамт олны харилцаа шинэ түвшинд гарч ажлын бүтээмж нэмэгдэн, хувь хүний үнэлэмж нэмэгдэн хамтдаа өсөж хөгжих боломж бүрдэнэ.	7 хоног	Нийт ажилтнууд	3,500,000 төгрөг
25	Усанд сэлэлтийн анхан шатны сургалт	Далбааны эзэн улсын хяналт шалгалт болон усан замын тээврийн хяналт хариуцсан мэргэжилтэн, улсын байцаагчдын ажил үүргээ аюулгүй гүйцэтгэх нөхцөл сайжирна.	Жилдээ	Нийт ажилтнууд	ХАБЭА-н төсөв
26	Үнэлгээний ажилтан бэлтгэх модуль сургалт /7 хоног/	Усан замын тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтад суралцагчдаас авах мэргэжлийн шалгалтыг зохион байгуулах	1-2 дугаар сард	Холбогдох мэргэжилтнүүд	1 хүний 210,000 төгрөг
27	Төрийн хяналт шалгалтын тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудын талаарх сургалт	Усан замын тээврийн хяналтын улсын байцаагчийн мэдлэг ур чадварыг дээшлүүлэх	I-II улирал	Далбааны эзэн улсын болон усан замын тээврийн хяналт хариуцсан мэргэжилтнүүд	400,000 төгрөг

28	БНСУ-ын Далайн тээвэр, загас агнуурын институтээс зохион байгуулдаг усан онгоц дээрх аюулгүй ажиллагааны талаар суурь мэдлэг олгох сургалт /олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сертификаттай/	Усан замын тээврийн хяналтын улсын байцаагчийн мэдлэг ур чавдарыг дээшлүүлэх	II улирал	Холбогдох мэргэжилтнүүд	1 хүний 6,000,000 төгрөг
----	--	--	-----------	-------------------------	-----------------------------

ДАРГА



Д.ОТГОНСҮРЭН